



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхаан тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/218-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2023 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: ЦЭСБ-Аудит ХХК Утас: 99499667 Цахим хаяг: infoaudit.selenge@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Аудитын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
 - 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитын
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЗГ	Засгийн газар
ХНХС	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ШААМАР
СУМЫН ДУЛААНХААН ТОСГОНЫ



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ШААМАР
СУМЫН ДУЛААНХААН ТОСГОНЫ
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Т.ЛЕНА
ТАНАА

2023-02-25 № 077-2023/218-НА-СТ-ТХЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхаан тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шаамар сумын Дулаанхаан тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Шаамар сумын Дулаанхаан тосгоны ерөнхий боловсролын сургууль нь үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 85.4 хувьтай тайлагнагдсан байна.

Цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 98,675.9 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 13,272.1 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 4,656.3 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 5,006.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс голлон шалтгаалж, нийт батлагдсан төсөв 14.6 хувиар хэмнэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Шаамар сумын Дулаанхаан тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 92.3 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал, 5.9 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал эзэлж байна.

Шаамар сумын Дулаанхаан тосгоны ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/343 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 2 дугаар түвшинд үнэлэгдэж урамшуулалд 16,264.5 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	86,688,040.09	236,454,005.82
31	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	-	124,142,942.22
311	Кассанд байгаа		124,142,942.22
312	Банкинд байгаа		124,142,942.22
33	АВЛАГА	-	450,000.00
335	Бусад авлага		450,000.00
	Хувь хүнээс авах		450,000.00
354	Хангамжийн материал	86,688,040.09	111,861,063.60
35410	Бичиг хэргийн материал	12,275,394.65	12,275,394.65
35420	Аж ахуйн материал	38,127,099.44	38,127,099.44
35450	Барилгын засварын материал	1,840,000.00	19,082,300.00
35470	Бусад хангамжийн материал	34,445,546.00	42,376,269.51
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	641,880,697.33	608,342,884.30
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	641,880,697.33	608,342,884.30
392	Биет хөрөнгийн дүн	632,860,297.33	599,322,484.30
39201	Барилга байгууламж	624,115,325.77	624,115,325.77
39202	Хуримтлагдсан элэгдэл	(60,165,154.26)	(81,081,317.34)
39205	Машин тоног төхөөрөмж	90,200,242.26	120,427,342.26
39206	Хуримтлагдсан элэгдэл	(69,089,639.73)	(109,176,901.23)
39207	Тавилга, эд хогшил	52,848,568.18	55,984,568.18
39208	Хуримтлагдсан элэгдэл	(29,414,993.27)	(34,815,861.40)
39209	Авто тээврийн хэрэгсэл	14,562,500.00	14,562,500.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(14,562,500.00)	(14,562,500.00)
39214	Бусад үндсэн хөрөнгө	18,046,740.22	18,046,740.22
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,246,674.40)	(5,894,024.16)
39217	Ном	9,565,882.56	11,716,612.00
393	Биет бус хөрөнгийн дүн	9,020,400.00	9,020,400.00
39301	Программ хангамж	250,000.00	250,000.00
39302	Хасагдуулга	(250,000.00)	(250,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	9,020,400.00	9,020,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	728,568,737.42	844,796,890.12
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	728,568,737.42	844,796,890.12
51	Засгийн газрын хувь оролцоо	319,214,929.37	319,214,929.37
511	Засгийн газрын оруулсан капитал		
51101	Өмч: -төрийн	319,214,929.37	319,214,929.37
512	Хуримтлагдсан үр дүн	(138,026,652.13)	(21,798,499.43)
51210	Өмнөх үеийн үр дүн	(138,026,652.13)	(866,595,389.55)
51220	Тайлант үеийн үр дүн		844,796,890.12
51300	Дахин үнэлгээний зөрүү	547,380,460.18	547,380,460.18
6	ӨР ТӨЛБӨР БА ЭЗ/ӨМЧИЙН ДҮН	728,568,737.42	844,796,890.12

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	645,278,232.95	1,602,205,839.27
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	87,514,548.10	1,895,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	87,514,548.10	1,895,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	65,477,563.90	1,895,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,895,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	65,477,563.90	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	5,099,943.26	647,167,426.77
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	16,937,040.94	103,493,263.60
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	557,763,684.85	849,649,648.90
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	510,962,600.00	771,478,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		771,478,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	510,962,600.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,611,400.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,611,400.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	41,951,441.85	78,171,048.90
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	41,951,441.85	78,171,048.90
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	238,243.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	238,243.00	
2	Үйл ажиллагааны зардал	661,522,871.15	757,408,949.15
21	Урсгал зардал	661,522,871.15	757,408,949.15
210	Бараа, үйлчилгээний зардал	637,129,088.85	698,440,399.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	412,336,446.80	494,016,626.10
210101	Үндсэн цалин	299,797,838.80	373,883,865.10
210102	Нэмэгдэл цалин	84,727,248.00	105,855,598.00
210104	Урамшуулал	27,811,360.00	14,277,163.00
2102	Нийгмийн даатгалын шимтгэл	53,528,673.90	61,518,515.58
210201	Тэтгэврийн даатгалын	37,869,550.87	42,481,265.15
210202	тэтгэмжийн даатгалын	4,193,698.67	4,985,221.04
210203	ҮОМШӨ-ий даатгалын	3,333,119.56	3,981,456.06
210204	Ажилгүйдлийн даатгалын	729,508.96	905,103.29
210205	ЭМ-ийн даатгалын	7,402,795.84	9,165,470.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,505,841.85	43,501,600.00
210301	Гэрэл цахилгааны зардал	4,127,169.88	6,178,267.31
210302	Түлш, халаалтын зардал	33,878,671.97	37,323,332.69
210303	Цэвэр бохир усны зардал	1,500,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	12,786,251.34	-
210401	Бичиг хэргийн зардал	658,500.00	
210404	Тээвэр шатахуун	650,000.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн зардал	1,400,900.00	
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	397,600.00	
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардал	2,264,094.94	
210408	Бараа материал акталсны зардал	7,415,156.40	
2105	Нормативт зардал	8,763,500.00	-
210502	Хоол, хүнс	8,114,100.00	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	117,900.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	531,500.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,283,500.00	2,203,300.00

210604	Урсгал засварын зардал	2,283,500.00	2,203,300.00
2107	Томилолтын зардал	178,300.00	-
210702	Дотоодын томилолт	178,300.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс	5,799,400.00	2,489,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	5,151,400.00	1,895,500.00
210802	Аудит баталгаажуулалтын зардал	648,000.00	
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ		594,000.00
2109	Бараа, үйлчилгээний бусад зардал	101,947,174.96	94,710,857.47
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		16,275,815.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	1,776,700.00	9,383,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	100,170,474.96	69,051,642.47
213	Урсгал шилжүүлэг		58,968,550.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,393,782.30	58,968,550.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	238,243.00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	9,521,320.00	42,704,050.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	400,000.00	16,264,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,234,219.30	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,234,219.30	-
3	Үйл ажиллагааны үр дүн	(16,244,638.20)	844,796,890.12
145	Үйл ажиллагааны бус орлогын дүн		
225	Үйл ажиллагааны бус зардлын дүн		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
4	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
5	Үйл ажиллагааны нийт үр дүн	16,244,638.20	844,796,890.12

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	561,486,592.85	851,545,148.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	510,962,600.00	1,895,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	1,895,500.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	1,895,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,895,500.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	510,962,600.00	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	510,962,600.00	
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	48,192,041.85	849,649,648.90
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	771,478,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		771,478,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,240,600.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,611,400.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,629,200.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	41,951,441.85	78,171,048.90
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	41,951,441.85	78,171,048.90
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,331,951.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,331,951.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	556,847,792.85	697,175,106.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	556,847,792.85	697,175,106.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	522,632,862.55	637,756,556.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	412,336,446.80	494,279,108.10
210101	Үндсэн цалин	303,530,447.24	374,007,965.10
210102	Нэмэгдэл	81,584,474.56	105,855,598.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,221,525.00	14,415,545.00
2102	Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,528,673.90	61,256,033.58
210201	Тэтгэврийн даатгалын	37,882,150.87	42,142,157.67
210202	Тэтгэмжийн даатгалын	4,193,698.67	5,002,589.55
210203	ҮОМШӨ-ий даатгалын	3,324,719.56	3,995,350.09
210204	Ажилгүйдлийн даатгалын	728,668.96	910,155.91
210205	Эрүүл мэндийн даатгалын	7,399,435.84	9,205,780.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,505,841.85	43,501,600.00
210301	Гэрэл цахилгааны зардал	4,127,169.88	6,178,267.31
210302	Түлш, халаалтын зардал	33,878,671.97	37,323,332.69
210303	Цэвэр бохир усны зардал	1,500,000.00	.
2104	Хангамж, бараа материал	5,852,500.00	-
210401	Бичиг хэргийн зардал	943,900.00	
210404	Тээвэр шатахуун	650,000.00	
210403	Шуудан холбооны зардал, мэдээлэл технологийн үйлчилгээ	1,400,900.00	
210404	Ном	1,629,200.00	
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	397,600.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	830,900.00	
2105	Нормативт зардал	589,400.00	-

210501	Эм	117,900.00	
210503	Нормын хувцас	471,500.00	
2106	Эд хогшил урсгал засвар	3,351,000.00	10,445,600.00
210604	Урсгал засвар	3,351,000.00	10,445,600.00
2107	Томилолт, зочны зардал	178,300.00	-
210702	Дотоодын томилолт	178,300.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж	5,619,400.00	3,494,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,971,400.00	1,895,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.00	
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ		1,599,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,671,300.00	24,779,415.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		15,396,015.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	1,671,300.00	9,383,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,214,930.30	59,418,550.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,980,711.00	59,418,550.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	2,331,951.00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	17,248,760.00	43,154,050.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	400,000.00	16,264,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,234,219.30	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,234,219.30	
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	4,638,800.00	154,370,042.22
	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	(4,638,800.00)	(30,227,100.00)
6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(4,638,800.00)	(30,227,100.00)
7	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх		
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	124,142,942.22
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		124,142,942.22

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны үр дүн
А	1	2	3	4
2019 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	319,214,929.37	547,380,460.18	(121,782,013.93)	744,813,375.62
НББ-ийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				-
ҮХ-ийн өсөлт, бууралт				-
ҮХ-ийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			(16,244,638.20)	(16,244,638.20)
2021 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	319,214,929.37	547,380,460.18	(138,026,652.13)	728,568,737.42
НББ-ийн бодлогын өөрчлөлт			(728,568,737.42)	(728,568,737.42)
ҮХ-ийн өсөлт, бууралт				-
ҮХ-ийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			844,796,890.12	844,796,890.12
2022 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	319,214,929.37	547,380,460.18	(21,798,499.43)	844,796,890.12

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	851,545,300.00	727,402,206.68	124,143,093.32	85.4
21	Урсгал зардлын дүн	851,545,300.00	727,402,206.68	124,143,093.32	85.4
210	Бараа үйлчилгээний зардал	789,594,400.00	667,983,656.68	121,610,743.32	84.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	592,955,000.00	494,279,108.10	98,675,891.90	83.4
210101	Үндсэн цалин	440,733,300.00	374,007,965.10	66,725,334.90	84.9
210102	Нэмэгдэл	138,942,300.00	105,855,598.00	33,086,702.00	76.2
210104	Урамшуулал	13,279,400.00	14,415,545.00	(1,136,145.00)	108.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,528,100.00	61,256,033.58	13,272,066.42	82.2
210201	Тэтгэврийн даатгал	50,685,800.00	42,142,157.67	8,543,642.33	83.1
210202	Тэтгэмжийн даатгал	5,963,100.00	5,002,589.55	960,510.45	83.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,770,400.00	3,995,350.09	775,049.91	83.8
210204	Ажилгүйдлийн даатгал	1,191,300.00	910,155.91	281,144.09	76.4
210205	ЭМД-ын хураамж	11,917,500.00	9,205,780.36	2,711,719.64	77.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,501,600.00	43,501,600.00	-	100.0
210301	Гэрэл цахилгааны зардал	6,374,300.00	6,178,267.31	196,032.69	96.9
210302	Түлш, халаалтын зардал	37,127,300.00	37,323,332.69	(196,032.69)	100.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,445,600.00	10,445,600.00	-	100.0
210604	Урсгал засвар	10,445,600.00	10,445,600.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	8,151,100.00	3,494,800.00	4,656,300.00	42.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	1,895,500.00	1,895,500.00	-	100.0
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	6,255,600.00	1,599,300.00	4,656,300.00	25.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	60,013,000.00	55,006,515.00	5,006,485.00	91.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	50,629,600.00	45,623,115.00	5,006,485.00	90.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,383,400.00	9,383,400.00	-	100.0
212	Татаас	61,950,900.00	59,418,550.00	2,532,350.00	95.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	61,950,900.00	59,418,550.00	2,532,350.00	95.9

2132	Бусад урсгал шилжүүлэг	61,950,900.00	59,418,550.00	2,532,350.00	95.9
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж				
213205	Төсвөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	45,686,400.00	43,154,050.00	2,532,350.00	94.5
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	16,264,500.00	16,264,500.00	-	100.0
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	851,545,300.00	851,545,148.90	151.10	100.0
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	771,478,600.00	771,478,600.00	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	771,478,600.00	771,478,600.00	-	100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих			-	
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	78,171,200.00	78,171,048.90	151.10	100.00
	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл			-	
	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		124,142,942.22		
001	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			-	
002	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
003	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
	АЖИЛЛАГСДЫН ТОО	39.00	39.00	-	100.0
	Удирдах ажилтан	3.00	3.00	-	100.0
	Гүйцэтгэх ажилтан	26.00	26.00	-	100.0
	Үйлчлэх ажилтан	10.00	10.00	-	100.0
010	СУРАЛЦАГЧДЫН ТОО /ЖИЛИЙН ДУНДЖААР/	373.00	373.00	-	100.0
015	Төрийн өмчит СӨБ байгууллага	1.00	1.00	-	100.0
024	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	39.00	39.00	-	100.0
032	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч			-	
033	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч	11.00	11.00	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхаан тосгоны ерөнхий боловсролын сургууль нь “Суралцагч бүрийн сурлагын хоцрогдлыг арилгая” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхэд бүрийг тэгш хамруулан сургах нөхцөлийг бүрдүүлж, сурлагын хоцрогдлыг арилгах.
- Хичээл сургалтын үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэн, цахим сан болон даалгаврын санг бүрдүүлж ашиглах.
- Багш бүр сургалтын арга хэлбэр, заах арга зүйгээ оновчтой сонгон заах,
- Багш, сурагч, эцэг эх, асран хамгаалагчдын хамтын ажиллагааг сайжруулж ажиллах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн байна.
- Төрийн хэмнэлтийн тухай тухай хууль хэрэгжиж эхэлсэн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон.
- Боловсролын тухай хуульд 2022 онд 3 удаа нэмэлт өөрчлөлт орсон,
- ЗГ-ын 2022 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай” журам хэрэгжиж эхэлсэн,
- ЗГ-ын 2019 оны 472 дугаар тогтоолын 5, 6 дугаар хавсралтаар батлагдсан “Шинжлэх ухааны байгууллага, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээ батлах тухай ” тогтоолд 2022 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- ЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчид олгох улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох” тогтоолд 2022 оны 252 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,

- БШУС-ын 2022 оны А/170 дугаар тушаалаар батлагдсан “Хичээл, сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ыг хэрэгжүүлж эхэлсэн,
- БШУС-ын 2022 оны А/465 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуульд, кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам”-ыг шинэчлэн баталсан,
- ХНХС-ын 2021 оны А/192 дугаар тушаалаар батлагдсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам” хэрэгжиж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Байгууллагын дотоод хяналтын албанаас ажлын төлөвлөгөө гарган хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд: Багш нарын хичээлийн бэлтгэл, сургалтын орчин, дотуур байр, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд зөвлөн туслах, хянан шалгах зэрэг ажлуудыг төлөвлөн хяналтыг хэрэгжүүлэн тайлагнасан байна.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шаамар сумын Дулаанхаан тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллага нь өмнөх онуудад тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсны хувьд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020 оны А/202 тоот захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн харьяа төсөвт байгууллагууд дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тайлант онд мөрдөж ирсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн

талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Шаамар сумын Дулаанхаан тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 116,228.1 мянган төгрөгөөр буюу 1.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		124,142.9	124,142.9
Авлага		450.0	450.0
Бараа материал	86,688.0	111,861.1	25,173.1
Үндсэн хөрөнгө	641,880.7	608,342.9	(33,537.8)
Нийт хөрөнгө	728,568.7	844,796.9	116,228.2
Өр төлбөр	-		
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	728,568.7	844,796.9	116,228.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	728,568.8	844,796.9	116,228.2

Тайлант жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлт 124,142.9 мянган төгрөгийг Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал”-ын 8.7-д “Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсан байна.

Авлага дансны үлдэгдэл 450.0 мянган төгрөг болж өссөн нь тайлант онд хувь хүмүүсээс авах авлага үүссэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 111,861.1 мянган төгрөг болж 25,173.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 76,874.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, Сэлэнгэ аймгийн БШУГ-аас 4,222.9 мянган төгрөгийн эрэгтэй технологийн хичээлийн хэрэглэгдэхүүн, Дэлхийн зөн ОУБ-аас 1,804.6 мянган төгрөгийн бусад хангамжийн материал, БШУЯ-наас 1,777.7 мянган төгрөгийн түрээсийн сурах бичиг, хичээлийн хэрэглэгдэхүүн нийт 7,805.2 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэж авсан бөгөөд үйл

ажиллагаанд 59,507.0 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 854,123.5 мянган төгрөг болж 35,513.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 30,227.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, БШУЯ-наас 1,878.1 мянган төгрөгийн сурах бичиг, Дэлхийн зөн ОУБ-аас 3,136.0 мянган төгрөгийн морин хуур хөгжим, эцэг эх сурагчдаас хандиваар 272.6 мянган төгрөгийн ном нийт 5,286.7 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 844,796.9 мянган төгрөг болж 116,228.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 726,523.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 51,192.8 мянган төгрөгөөр нийт зарлагыг 777,716.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд хийсэн төсвийн зохицуулалтаар цалин, НДШ-ийн зардлыг 73,829.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн нийт төсвийг 851,545.3 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 771,478.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 78,171.2 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 1,895.5 мянган төгрөг нийт 851,545.3 мянган төгрөгийн эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд захиран зарцуулахаар төлөвлөгдсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 727,402.2 мянган төгрөг буюу 85.4 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл зардал 98,675.9 мянган төгрөг, НДШ-ийн зардлаас 13,272.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 4,656.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 5,006.5 мянган төгрөгийг тус тус хэмнэн 124,143.1 мянган төгрөгийг үлдэгдлээр тайлагнасангай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Биелэлт	
1	71802 Ерөнхий боловсрол	1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	2,502.2	2,502.2	-	100.0	
		2	80312- Сургалт семинар	1,251.1	1,251.1	-	100.0	
		3	81605- Эрүүл мэндийг дэмжих	2,877.6	1,879.0	998.6	65.3	
		4	81801- Үдийн цай хөтөлбөр	45,686.4	43,154.1	2,532.3	94.46	
		5	81806- Дотуур байрны үйлчилгээ					
		6	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	25,475.0	21,469.2	4,005.8	84.28	
		7	81823- Боловсролын багшийн сургалт	5,630.0	5,630.0	-	100.0	
		8	81834- Боловсролын стандарт сургалт	588,472.7	497,060.8	91,411.9	84.47	
		9	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	99,583.8	74,389.3	25,194.5	74.7	
		10	81844- Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн					
		11	81848-Сурах бичгийн түрээс	1,895.5	1,895.5	-	100.0	
		12	83602-ЗГ болон ЗД-ын нөөц хөрөнгөөс хуваарилсан				-	100.0
		13	83603- Дээд шатны төсвөөс				-	100.0
		14	80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	53,947.2	53,947.2	-	100.0	
		15	80112- Нийтлэг үйлчилгээ	24,223.8	24,223.8	0.1	99.9	
Нийт				851,545.3	727,402.2	124,143.1	85.4	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд орлого төвлөрүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шаамар сумын Дулаанхаан тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал,

дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын санхүүгийн тайлангийн тайлбар тодруулгатай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн аудитор Т.Эрдэнэтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Шаамар сумын Дулаанхаан тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг ЦЭСБ-Аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 661,552.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 6,615.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Боловсролын ерөнхий газраас нийт боловсролын байгууллагуудад 2022 оны 04, 09 дүгээр саруудад төрийн хэмнэлтийн тухай хууль болон ЗГ-ын 2022 оны 203 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, төсвийн хэмнэлтийн горимоор ажиллах, орон тоог хязгаарлах, төрийн үйл ажиллагааг цахимжуулах, бараа үйлчилгээний зардлыг бууруулах, зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Шаамар сумын Дулаанхаан тосгоны Ерөнхий боловсролын сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дараах байдлаар хэрэгжүүлжээ. Үүнд:

- Боловсролын салбарын үр дүнд суурилсан санхүүжилтийг нэвтрүүлж батлагдсан орон тоогоор бус гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотойгоор цалин, ажил олгогчоос төлөх НДШ, үдийн цай хөтөлбөр, сургалт семинарын зардлаас нийт 124,143.1 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд боловсролын байгууллагын мэдээлбэл зохих 20 төрлийн 151 мэдээллээс 6 мэдээллийг хугацаа хоцроосон бөгөөд мэдээллийн хэрэгжилт 90.7 хувьтай байна. Үүнд:

- Тухай бүр мэдээлэх мэдээллийг 6 удаа

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс тайлант онд алдаа зөрчил давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.10 дахь "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэсэн заалтыг үндэслэн албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“ЦЭСБ-Аудит” ХХК-ийн 2022 оны 11 дүгээр 02-ны 01/215 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” захидлыг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй 3,680.4 мянган төгрөгийн, шилэн дансны цахим хуудсанд 17 мэдээллийг хугацаа хоцроосон зөрчлийг давтан гаргахгүй ажиллах талаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-

Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	2	3,680.4	1	3,680.4	60.0
Нийт дүн	2	3,680.4	1	3,680.4	60.0

Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлууд нь тухайн төсвийн захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн учир Шаамар сумын Дулаанхаан тосгоны ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчлөөр тооцоолгүйгээр дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.
2. Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан “Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан” гэсэн зориулалтаар, төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого / 120010 / ангиллаар гүйцэтгэхээр чиглэл хүргүүлсэн байна. Нэмэлтээр хуваарилах төсвийн эх үүсвэрийг төсвийн санхүүжилтийн эх үүсвэр болгон төлөвлөж байгаагаас гүйцэтгэлээр уг санхүүжилт хуваарилагдаагүй тохиолдолд төсвийн санхүүжилтийн төлөвлөгөө тасарснаар тайлагнагдах эрсдэлийг үүсгэж байна. Иймд дээд шатны төсвөөс хуваарилах нэмэлт төсвийг төсвийн санхүүжилт хэлбэрээр урьдчилан төлөвлөж, батлалгүйгээр санхүүжилт ирсэн тухай бүр тухайн санхүүжилтийн дүнгээр зарцуулах эрх тавих нь зүйтэй юм.
3. Тус байгууллага нь өмнөх жилүүдэд тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсан учир Сэлэнгэ аймгийн ЗД-ын 2020 оны 7 дугаар сарын 16-ний өдрийн А/202 дугаар захирамжаар баталсан “Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад

мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж ирсэн байна. Бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч боловсролын байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирохгүй учир төсвийн ерөнхийлөн захирагчийн боловсруулсан НБББББ-ыг мөрдөх нь зүйтэй юм.

5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа илрээгүй болно.

Аудитаар нийт **2,195.6** мянган төгрөгийн зөрчил¹ илэрч 2,195.6 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

5.1 Албан шаардлага

1. Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд төлбөрийн цахим баримтаар баталгаажаагүй **1,745.6** мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэж, бүртгэсэн буюу зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь *“Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”*, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь *“Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх *“Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”*, 4.2.1.10: *“Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол”* гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

2. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас **450.0** мянган төгрөгийн хувь хүмүүсээс авах авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь *“Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *“дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж, төлбөр тооцоог урьдчилан хянасны үндсэн дээр өр төлбөр, авлага үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх

5.2.Зөвлөмж

1.1 Санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дахь “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна.”, 8.1.5 дахь “санхүүгийн тайлангийн тодруулга” гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, онцлог байдлыг илтгэсэн тайлбар, тодруулгуудыг хийж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цахим төлбөрийн баримтгүйгээр ажил гүйлгээг хийсэн	1	1,745.6			1	1,745.6						
Хувь хүнээс авах авлага үүсгэсэн	1	450.0			1	450.0						

Санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй	1					1					
Дүн	3	2,195.6			2	2,195.6	1				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд 6 мэдээллийг хугацаа хоцроосон	6				6			
Дүн	6				6			
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	6				6			